



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 57245

Улаанбаатар хот

Таван төрөлт тэмцээн зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх” зорилтот жилийн хүрээнд дүүргийн төрийн албан хаагчдын дунд 5 төрөлт тэмцээнийг 2025 оны 10 дугаар сарын 18-наас 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл зохион байгуулсугай.

2.Тэмцээний удирдамжийг нэгдүгээр, зарцуулагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3.Тэмцээнд зарцуулагдах 3.228.000 (Гурван сая хоёр зуун хорин найм мянга)-н төгрөгийг Засаг даргын Тамгын газрын холбогдох зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

4.Тэмцээнийг чанартай үр дүнтэй зохион байгуулж, санхүүгийн тайланг 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн дотор Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Биеийн тамир спортын хороо (Тэмүүлэн)-нд үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн
1025 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

УДИРДАМЖ



2025 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Багахангай дүүрэг

**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ДУНД
5 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ ТУХАЙ**

НЭГ: ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО

Түншлэл-Үйлчилгээний соёлыг дээшлүүлэх зорилтот жилийн хүрээнд төрийн албан хаагчдын оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, нөхөрсөг уур амьсгал бүрдүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, бие бялдрыг чийрэгжүүлэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд тэмцээний зорилго оршино.

ХОЁР. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

Тэмцээний техникийн зөвлөгөөнийг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр 15:00 цагт Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулж тэмцээн явагдах дүрмийг танилцуулна. Тэмцээнд оролцох багийн ахлагч мэдүүлэгтэйгээ ирнэ. Мэдүүлгийг төрөл тус бүрээр гаргаж байгууллагын даргаар баталгаажуулсан байх.

/Жич: Шаардлага хангаагүй мэдүүлэг авахгүй болно./

Мэдүүлгийн загвар

Батлав.....

№	Овог нэр	Нас	Хүйс	Тоглогчийн үүрэг	Утасны дугаар	Албан тушаал	Эрүүл мэнд
1							

Мэдүүлэг гаргасан:

ГУРАВ. ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ХУГАЦАА.

Тэмцээн 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 25-ны өдрийн хооронд зохион байгуулагдана.

ДӨРӨВ: ОРОЛЦОХ БАГУУД

Тэмцээнд Багахангай дүүргийн төрийн албан хаагчид байгууллагаасаа баг бүрдүүлж оролцоно.

Засаг даргын дэргэдэх хэлтэс албад 1 баг болж оролцоно.

Бусад асуудлыг техникийн зөвлөгөөн дээр ярилцана.

ТЭМЦЭЭН ЯВАГДАХ ТӨРӨЛ

№	Явагдах төрөл	Хугацаа	Оролцох бүрэлдэхүүн	Хаана
1	Волейбол	X/18 08 цагт	Эрэгтэй, эмэгтэй тусдаа 8 хүний бүрэлдэхүүнтэй.	БТСХ
2	Хөзөр	X/22 13 цагт	Эрэгтэй 2, эмэгтэй 2 тамирчин оролцоно.	
3	Корнхол	X/23 13 цагт	Эрэгтэй 2, эмэгтэй 2 тамирчин оролцоно.	
4	Бадминтон	X/24 13 цагт	Эрэгтэй 1, эмэгтэй 1 тамирчин оролцоно.	
5	3х3 сагсан бөмбөг	X/25 09 цагт	Эрэгтэй, эмэгтэй тусдаа 5 хүний бүрэлдэхүүнтэй.	

ТАВ: ТЭМЦЭЭНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Тамирчид жигд хувцастай байх.
- Гадны пүүзээ сольж талбай дээр гарах
- Шүүгчидтэй маргалдахыг хатуу хориглоно
- Тэмцээнд оролцогчид нь зөвхөн Багахангай дүүрэгт ажиллаж байгаа төрийн алба хаагч байна.
- Мэдүүлэгт ороогүй тамирчин оролцох боломжгүй.
- Тэмцээн цагийн хуваарийн дагуу явагдах тул 5 минут хүлээгээд ирэхгүй багийн хожлыг эсрэг багт өгнө.

ДОЛОО: ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

ТӨРӨЛ ТУС БҮРД

Тэргүүн байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Дэд байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

Гутгаар байр - Өргөмжлөл, мөнгөн шагнал

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ
БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ЗҮҮНИЙ ХҮЧНИЙ ХОЛБОО

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 10 дугаар сарын 16 ны өдрийн
А/ЗХ дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТЭМЦЭЭНД ЗАРЦУУЛАГДАХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
Волейбол					
1	1-р байр	ш	2	250.000	500.000
2	2-р байр	ш	2	200.000	400.000
3	3-р байр	ш	2	150.000	300.000
3х3 Сагсан бөмбөг					
4	1-р байр	ш	2	180.000	360.000
5	2-р байр	ш	2	150.000	300.000
6	3-р байр	ш	2	120.000	240.000
Хөзөр					
7	1-р байр	ш	1	120.000	120.000
8	2-р байр	ш	1	100.000	100.000
9	3-р байр	ш	1	80.000	80.000
Корнхол					
10	1-р байр	ш	1	120.000	120.000
11	2-р байр	ш	1	100.000	100.000
12	3-р байр	ш	1	80.000	80.000
Бадминтон					
13	1-р байр	ш	1	80.000	80.000
14	2-р байр	ш	1	60.000	60.000
15	3-р байр	ш	1	40.000	40.000
Бусад зардал					
16	Аннос	ш	3*4		198.000
17	Жааз	ш	15	10.000	150.000
Нийт зардал					3.228.000